



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 90,920,633.15 (ерэн сая есөн зуун хорин мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 89,842,139.45 (наян есөн сая найман зуун дөчин хоёр мянга нэг зуун гучин есөн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч цагдаагийн хурандаа С.Баатаржав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А. АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн
1.8-р дугаар тогтоолын хавсралт

6098169 1118262983

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн
1.8-р дугаар тогтоолын хавсралт

Сангийн яамнаас Цагдаагийн ерөнхий газарт
балансаас балансад шилжүүлэн өгөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Дижитал индэр	6/30/2012	1	26,200,000.00	26,200,000.00	26,200,000.00	0.00
2	Камер IP PTZ	6/30/2012	1	690,000.00	690,000.00	690,000.00	0.00
3	Массажны сандал	6/30/2012	2	5,018,475.00	10,036,950.00	10,036,950.00	0.00
4	Хувилалч Коника	6/29/2013	1	4,388,640.00	4,388,640.00	4,388,640.00	0.00
5	Принтер P3015	6/29/2013	1	1,291,730.00	1,291,730.00	1,291,730.00	365,720.00
6	Принтер Samsung 3400	6/29/2013	1	217,550.00	217,550.00	199,420.65	107,644.35
7	Дэлгэц Samsung NC220	12/5/2013	1	1,320,000.00	1,320,000.00	1,078,000.00	18,129.35
8	Компьютер Dell 9010	5/1/2012	5	1,475,000.00	7,375,000.00	7,375,000.00	242,000.00
9	Принтер Epson	8/26/2010	1	679,998.00	679,998.00	679,998.00	0.00
10	Дэлгэц Dell 23 инч	9/27/2014	10	368,000.00	3,680,000.00	3,335,000.00	345,000.00
11	Проектор	12/31/2009	1	1,389,090.91	1,389,090.91	1,389,090.91	0.00
12	Проектор	12/31/2009	1	5,294,171.74	5,294,171.74	5,294,171.74	0.00
13	Проектор	12/31/2009	1	5,469,502.50	5,469,502.50	5,469,502.50	0.00
14	Компьютер Dell 390	11/19/2012	4	1,375,000.00	5,500,000.00	5,500,000.00	0.00
15	Компьютер Dell Optilex990	1/25/2012	12	1,449,000.00	17,388,000.00	17,388,000.00	0.00
	Нийт дүн		43		90,920,633.15 (ерэн сая есөн зуун хорин мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө)	89,842,139.45 (наян есөн сая найман зуун дөчин хоёр мянга нэг зуун гучин есөн төгрөг дөчин таван мөнгө)	1,078,493.70 (нэг сая далан найман мянга дөрвөн зуун ерэн гурван төгрөг далан мөнгө)